



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 11 болон 12 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 03-р сарын 24-наас 04-р сарын 02-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 5 дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Хүснэгт 1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд (2021-2022)

	2021				2022			
	I	II	III	IV	I	II	III	IV
АНУ	0.3	13.1	7.7	7.7	7.2	5.5	4	4
Евро бүс	-2.1	13.2	2.7	4.7	6.5	4.8	3.4	2.7
БНХАУ	20.1	8	6.5	5.6	5.7	5.6	5.5	5.5
ОХУ	-1.2	9.6	4.6	3.2	3	2.7	2.8	3
Япон	-2.5	7.8	3.2	0.8	3	2	1.6	1.5

- ОУВС-гийн 2021 оны 1-р сарын төсөөллөөр дэлхийн эдийн засаг энэ онд 5.5 хувиар, 2022 онд 4.2 хувиар өсөх тооцоололтой байв. Харин ОУВС ирэх 4-р сард шинэчлэн зарлах дэлхийн эдийн засгийн төсөөллийг сайжруулахаа мэдэгдсэн бөгөөд үүнд АНУ болон БНХАУ-ын эдийн засаг хурдтай сэргэж байгаа нь голлон нөлөөлөхөөр байна. Тухайлбал, АНУ-ын эдийн засгийг сэргээх 1.9 их наяд ам.долларын багц хөтөлбөр батлагдсаны зэрэгцээ улс орнуудад вакцинжуулалтын үйл явц эрчимжиж байгаа нь эдийн засгийн сэргэлтийг түргэсгэхээр байна. Хямралын өмнөх үеийн 2022 оны төсөөлөлтэй харьцуулахад хөгжингүй улс орнуудын нэг хүнд ногдох ДНБ 2022 онд 11

Эх сурвалж: Блүүмберг агентлаг
хувиар бага, хөгжиж буй орнуудын хувьд 20 хувиар бага түвшинд хүрэх төлөвтэй байна. 2020 оны эхнээс 2021 оны 3-р сар хүртлэх хугацаанд цар тахалтай тэмцэх зорилгоор Засгийн газрууд төсөв, мөнгөний бодлогоор нийт 16 их наяд ам.долларын төсвийн шинж чанартай арга хэмжээ аваад байна. ОУВС-гийн тооцооллоор буурай хөгжилтэй улс орнууд зөвхөн цар тахлын эсрэг хариу арга хэмжээнд ирэх 5 жилийн хугацаанд нийт 200 тэрбум ам.доллар зарцуулах бол орлогын түвшинээ дээшлүүлж, хөгжлийн замдаа эргэж ороход дахин 250 тэрбум ам.доллар шаардлагатай гэжээ. ОУВС нийт 85 оронд 17 тэрбум ам.долларын санхүүжилт олгосон бол нэн ядуу 29 улс орны гадаад өрийг тэглээд байна.

- **Mckinsey** байгууллагын 2021 оны 3-р сарын 30-ны дэлхийн эдийн засгийн төлөв байдлын түүвэр судалгааны үр дүнгээр дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, өсөлт үргэлжлэх хүлээлттэй байгааг мэдээллээ. Тодруулбал, нийт судалгаанд оролцсон гүйцэтгэх захирлуудын 56 хувь нь өнгөрсөн 6 сарын хугацаанд нөхцөл байдал сайжирсан гэж үзсэн ба 69 хувь нь ирэх 6 сард эдийн засгийн өсөлт үргэлжлэх хандлагатай гэж үзжээ¹. Түүнчлэн, АНУ, БНХАУ, Энэтхэгт өсөлтийн хүлээлт сайжирсан бол Латин Америкт хүлээлт өмнөх түүвэр судалгаанаас бага зэрэг мууджээ. Ирэх 6 сард гүйцэтгэх захирлуудын 43 хувь нь ажилгүйдэл буурна гэж үзсэн бол 38 хувь өсөх хүлээлттэй байна. Газарзүйн байрлалаар авч үзвэл АНУ-д ажилгүйдэл буурах, Евро бүсэд ажилгүйдэл өсөх хүлээлт давамгайлж байна. Ажиллах хүчний хэмжээг авч үзвэл 43 хувь нь буурах, 39 хувь нь өсөх, 19 хувь нь өрчлөгдөхгүй гэсэн хүлээлттэй байна. Бизнесийн салбарын хувьд 63 хувь нь ирэх 3 жилд эрэлт нэмэгдэж нөхцөл байдал сайжирна гэж хүлээж байна.
- **Евро бүсийн PMI** өмнөх сард 57.9 байсан бол **2020 оны 3-р сарын 24-ний байдлаар 62.4 болж нэмэгдлээ**. Харин Евро бүсийн ажилгүйдлийн түвшин өмнөх сартай ижил буюу 6.5 хувьд хадгалагдаж байна. John Hopkins их сургуулийн төсөөллөөр Евро бүсэд хөл хорио алгуур суларч, 5, 6-р саруудад эдийн засаг хэвийн түвшинд шилжих тохиолдолд хоёр болон гуравдугаар улирлын эдийн засгийн өсөлт дунджаар 2 хувьд хүрэхээр байгаа хэдий ч энэ нь Bloomberg агентлагийн төсөөллөөс бага байна (Хүснэгт 1). Түүнчлэн, эдийн

засгийг сэргээх хөтөлбөрт **Европын холбоо 700 тэрбум еврог төсөвлөжээ**.

- **Их Британийн жижиглэн худалдааны өсөлт** 2021 оны 2-р сард 2.2 хувьд хүрч нэмэгдлээ. Тус улсын Засгийн газраас хөл хорионы дэглэмийг 4-р сарын 12-оос эхлэн сулруулж зарим төрлийн бизнесийн үйл ажиллагааг нээх зөвшөөрөл олгосон нь иргэдийн худалдан авах эрэлтийг өдөөсөн гэж үзэж байна. Түүнчлэн, 3-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр PMI 56.6 буюу өмнөх сарын 49.6 үзүүлэлттэй харьцуулахад өсөхөөр байна. **2020 оны 4-р улиралд Их Британийн ДНБ 7.3 хувиар агшсан бол** оны 1-р улиралд 3 хувиар буурах төлөвтэй.
- АНУ-ын нэгдсэн PMI 2021 оны 3-р сарын 24-ний байдлаар 59.1 байгаа нь аж үйлдвэрлэлийн сэргэлт үргэлжилж байгааг илтгэж байна. АНУ-д Ковид-19 цар тахлын эсрэг вакцинжуулалт эрчимжиж, хөл хорионы дэглэм суларснаар ажилгүйдлийн түвшин буурав. Түүнчлэн, ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо өмнөх долоо хоногтой харьцуулахад 2021 оны 3 дугаар сарын 20-ны тайлант долоо хоногт 13.9 хувиар буурч, 684 мянга байсан бол 3 дугаар сарын 27-ны тайлант долоо хоногт 5.1 хувиар өсч 719 мянгад хүрлээ. Холбооны нөөцийн банк өнгөрсөн оны эцсээр 2021 оны 1-р улирлын **инфляцын төсөөллийг 1.4 хувь гэж төсөөлж байсан бол шинэчилсэн төсөөллөөр 2.2 хувь болгож** нэмэгдүүлжээ. Инфляцын гүйцэтгэлийн хувьд энэ оны 1-р сард 1.4 хувь, 2-р сард 1.7 хувьтай байна. Тус улсын эдийн засаг энэ оны сүүлийн хагаст цар тахлын өмнөх үеийн түвшинд хүрнэ гэж таамаглаж байгаа бөгөөд урт хугацааны төсөөллөөр 2020-2029 онд дунджаар 1.6 хувиар өсөх

¹ Өмнөх түүвэр судалгаанд уг үзүүлэлт 56 хувь байсан.



төлөвтэй байна. Хөрөнгө оруулагчид Ковид-19-ийн вакцинжуулалтын явц болон эдийн засгийг сэргээх багц хөтөлбөрт эерэг хүлээлттэй байгаа боловч инфляцын зорилтот түвшин 2 хувиас давах хүлээлтээс шалтгаалан АНУ-ын 10 жилийн хугацаат Засгийн газрын үнэт цаасны өгөөж оны эхнээс 0.8 нэгж хувиар нэмэгдэж **2021 оны 3-р сарын эцэст 1.72 хувьд хүрэхэд нөлөөлөв.** АНУ вакцинжуулалтаа эрчимжүүлж, өдөрт 3 сая тун вакцин хийж эхлэхээ мэдэгдээд байна. Тухайлбал, 3-р сарын сүүлийн 3 хоногт 10 сая тун вакцинжуулалт хийжээ.

- 2021 оны 2-р сард Фитч зээлжих зэрэглэл тогтоогч агентлагаас цар тахалтай холбоотойгоор Япон улсын зээлжих зэрэглэлийг А–тогтвортой байснаас А–сөрөг болгож төлөвийг бууруулсан билээ. Тус улсын эдийн засаг сэргэж буй хэдий ч ойрын хугацаанд зээлжих зэрэглэлийн төлөвийг сайжруулахгүй гэдгээ мэдэгдээд байна. Японы эдийн засаг сэргэхэд хэд хэдэн хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байгааг шинжээчид онцолж байна. Тухайлбал, вакцинжуулалтын явц удааширч, Олимпын үйл ажиллагаатай холбоотойгоор төсвийн

дарамт нэмэгдэхээр байгаагийн зэрэгцээ цар тахлын гурав дахь давалгаа эхэлж, Засгийн газраас онц байдал зарласан нь 1-р улирлын эдийн засгийн төлөв муудахад нөлөөлж байна. Цар тахлаас шалтгаалан 2020 онд **Японы эдийн засаг 4.8 хувиар агшсан бол энэ онд 2.2 хувиар өсөх төсөөлөлтэй.** Түүнчлэн, **77 их наяд иений эдийн засгийг сэргээх хөтөлбөр** батлагдсан нь урт хугацаанд төсвийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй гэж шинжээчид дүгнэж байна.

Эх сурвалж:

1. Fitch Rating , [Fitch Affirms Japan at 'A'; Outlook Negative](#)
2. Financial Times, [Bank of England clamps down on Brexit – driven EU relocations](#)
3. BBC, [UK economy suffered record annual slump in 2020](#)
4. McKinsey & Company, [Economic conditions outlook, March 2021](#)
5. The National News, [IMF to upgrade world economic outlook on vaccines and stimulus boost](#)
6. Financial Times, [British retail sales return to growth, driven by home improvements](#)
7. IMF, [Giving People a Fair Shot—Policies to Secure the Recovery](#)
8. Continuum Economics, [Government Debt Trends Sustained by Nominal GDP and Easy Central Banks](#)
9. Euro area insight: Jab Fiasco + Fiscal Fail = Peak Pessimism

2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **БНХАУ-ын үл хөдлөх салбарын хөрөнгө оруулалт² идэвхжиж байна.** Оны эхний 2 сард орон нутгийн өрхүүдийг хассан үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт 4.5 их наяд юаньд хүрч өмнөх оны мөн үеэс 35 хувиар

нэмэгдэв. Үүний нөлөөгөөр оны эхний 2 сард дэд бүтцийн салбар дахь барилга байгууламжийн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 36.6 хувиар нэмэгдсэн бол боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь хөрөнгө оруулалт 37.3 хувиар нэмэгджээ. Үүнд өмнөх жилийн бага суурь үеийн нөлөө байгааг “Sxcoal” байгууллагын сарын тайланд онцлов. Үл хөдлөх салбарын

² FAI – fixed asset investment

хөрөнгө оруулалт оны эхний 2 сард 1.4 их наяд юань хүрч өмнөх оны мөн үеэс 38.3 хувиар нэмэгдсэн байна. Тодруулбал, орон сууцны салбар дахь хөрөнгө оруулалт 1 их наяд юань хүрч өмнөх жилээс 41.9 хувиар өсч, шинээр ашиглалтад орсон шалны талбай 170.4 сая м² хүрч өмнөх оны мөн үеэс 64.3 хувиар өсөв.

- **Ган үйлдвэрлэлийн салбарын идэвхжил эрчимжив.** Ган үйлдвэрлэлийн PMI индекс 2021 оны 2-р сард сэргэн 48.6-д хүрч өмнөх сараас 4.3 нэгжээр нэмэгдэв. Өсөлтөд дотоодын ган үйлдвэрлэлийн зах зээл сэргэсэн, гадаад эрэлт нэмэгдсэн, гангийн үйлдвэрлэл, нөөц тус тус нэмэгдсэн зэрэг нь нөлөөлөв. БНХАУ-ын түүхий гангийн үйлдвэрлэл оны эхний 2 сард 174.9 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар нэмэгдлээ. Тухайлбал, Хэбэй, Шандонг, Жиангсу болон Лиаонинг мужийн үйлдвэрлэл 10.3 сая тонн, 13.2 сая тонн, 20.3 сая тонн, 12.9 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 4.2%, 8.5%, 13.9%, 5%-иар тус тус нэмэгдээд байна.
- **Автомашинны үйлдвэрлэл** 2021 оны 2-р сард 1.5 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 427.4 хувь, өмнөх сараас 37.1 хувиар өслөө. Харин оны эхний 2 сарын сарын нийлбэр дүнгээр үзвэл 3.9 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 89.9 хувиар өсөв. Түүнчлэн, автомашины худалдаа 2-р сард 1.46 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 364.8 хувиар нэмэгдсэн бол өмнөх сараас 41.9 хувиар буурав. Оны эхний 2 сарын нийлбэр дүнгээр тооцвол автомашины худалдаа 4.0 саяд хүрч жилийн 76.2 хувиар өсчээ.
- **БНХАУ-ын коксын үйлдвэрлэл** оны эхний 2 сард 79.1 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар нэмэгдэв. Үүнд Шанси мужийн үйлдвэрлэл оны эхний 2 сард 16.5 сая тонн буюу жилийн 12.9 хувиар, ӨМӨЗО-ны

үйлдвэрлэл 7.8 сая тонн буюу жилийн 22.5 хувиар тус тус нэмэгдсэн нөлөөлсөн байна. Коксын импорт оны эхний 2 сард 0.36 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 140 хувиар өссөн бол 2-р сард ОХУ, Япон, Монгол Улсаас голлон 164 мянган тонн кокс импортолсон нь жилийн 173.3 хувиар өсөв.

- **БНХАУ-ын гангийн экспорт** оны эхний 2 сард 10.1 сая тоннд хүрч жилийн 29.8 хувиар өссөн бол гангийн импорт 2.4 сая тонн хүрч жилийн 17.6 хувиар өсчээ.
- **БНХАУ-ын дотоодын угаасан коксжих нүүрсний нийлүүлэлт** оны эхний 2 сард 76.9 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар өссөн байна. Мужуудаар нь авч үзвэл Шанси, Гуйжоу, Хенан мужийн үйлдвэрлэл оны эхний 2 сард харгалзан 36.9 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 34.7 хувиар, 3.6 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 58.8 хувь, 3.8 сая тонн тус тус хүрч өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар тус тус нэмэгдэв. Харин Шандонг мужийн үйлдвэрлэл оны эхний 2 сард харгалзан 6.9 сая тонн буюу өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар буурав.
- **БНХАУ-ын коксжих нүүрсний нийт импорт 2-р сард** 3.2 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 38.7 хувиар буурлаа. БНХАУ улс 2021 оны эхний 2 сард Австралиас коксжих нүүрс огт импортлоогүй байна. Монгол Улсаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 2-р сард өмнөх оны мөн үеэс 253.7 хувиар нэмэгдэж 1.74 сая тоннд хүрсэн бол оны эхний 2 сарын нийлбэрээр авч үзвэл өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар буурч 3.92 сая тоннд хүрчээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт, голлох орноор

	2021 оны 2-р сар		2021 оны эхний 2 сар	
	Импорт, (сая тонн)	Жилийн өөрчлөлт %	Импорт, (сая тонн)	Жилийн өөрчлөлт %
Монгол	1.74	253.7%	3.92	-11.3%
Австрали	0	-100%	0	-100%
ОХУ	0.58	-5.1%	0.84	-11.3%
Канад	0.42	86.6%	0.77	-17.1%

- Ганцмод боомтоор нэвтэрч буй нүүрсний ачааны машины тоо 2021 оны 3-р сард дунджаар өдрийн 539 хүрч өмнөх сараас 41.8 хувиар нэмэгдэснийг sxcoal байгууллага мэдээлэв. Энэ оны 2-р сарын сүүлийн хагас, 3-р сарын эхний хагаст нүүрсний экспорт эрчимжиж байсан хэдий ч манай улсад цар тахлын тархалт нэмэгдэж буй нөлөөгөөр БНХАУ-ын гаалийн хяналт шалгалт чангарч, Монголоос импортлох коксжих нүүрсний импортод хязгаарлалт тавих болсноор 3-р сарын 26-ны байдлаар

Ганцмод боомтоор нэвтрэх машины тоо 29 хүрч буурав. Түүнчлэн, 3-р сарын 30-ны өдөр Шивээхүрэн боомт дээр нүүрсний тээврийн жолоочоос Ковид-19-ийн халдвар илэрснээр тус боомтоорх нүүрсний тээвэр түр зогсоод байна.

Эх сурвалж:

- China Coking Coal Coke market monthly, Fenwei Digital Information Technology Co.Ltd*
- Fenwei Coal Weekly update March 29, Fenwei Digital Information Technology Co.Ltd*

3

МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							
	Үнэ (-1 day) 2021/03/31	Өөрчлөлт					Товч тайлбар
		daily	weekly	monthly	year to date	YoY	
Зэс	8787.7	0.0%	0.0%	-3.8%	13.4%	77.9%	Дэлхийн хэмжээнд КОВИД-19-ийн халдварын тохиолдол нэмэгдсээр байгаа ч улс орнуудад вакцинжуулалт үргэлжилж байгаа нь зах зээлд оролцогчдын итгэлд эерэгээр нөлөөлж үнэ өмнөх долоо хоногийн түвшинд хадгалагдахад нөлөөлж байна.
Төмрийн хүдэр	155	0.0%	0.1%	-6.2%	1.5%	92.3%	БНХАУ улс энэ онд барилгын салбараа эрчимтэй дэмжих хүлээлтийн улмаас төмрийн хүдрийн эрэлт өндөр байх төлөвтэй тул үнэ өмнөх долоо хоногийн түвшинд хадгалагдаж байна.
Алт	1707	0.4%	-0.7%	-1.2%	-9.7%	7.7%	Хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа нь алтны эрэлт, үнэ өндөр байхад нөлөөлж байгаа хэдий ч улс орнуудад вакцинжуулалт хийгдэж буй нь зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулах нөлөө давамгайлж алтны үнэ өмнөх долоо хоногоос буурахад нөлөөллөө.
Газрын тос (Брент)	63.5	0.5%	3.1%	0.3%	25.0%	158.1 %	ОПЕК+-ийн нэгдэл ээлжит хурлаараа нийлүүлэлтээ энэ оны 5-р сараас цаашаа үргэлжлүүлэн бууруулах хүлээлт газрын тосны үнийг өмнөх долоо хоногоос өсгөх чиглэлд нөлөөлж байна.